МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 10 өдөр Дугаар А/414 Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэг, 47 дугаар зүйлийн 47.2.2 дахь заалт, Үнэлгээний хорооны 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 97 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжилт хийгдэх ГААОНӨГ/202001012 дугаартай Хүнхэр зуслангийн байрнуудын барилгын засварын ажлын 1 дүгээр багцыг "Дөл өөдөө" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ)-т олгосугай.

2.Гүйцэтгэгчийн санал болгосон ажил гүйцэтгэх хугацаа, ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт зэргийг үндэслэн холбогдох хууль, журмын дагуу эрх үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Ч.Бат-Эрдэнэ), Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар (М.Ууган-Эрдэнэ) нарт үүрэг болгосугай.

3.Санхүүжилтийн гүйцэтгэл, ажлын чанарт хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ч.Жаргалсайхан), Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (П.Баасан)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ Ж.ГАНБАТ

C:/My documents/ZAHNR-3A-4 doc

0261200989